



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/232

Арвайхээр сум

Хорио цээрийн дэглэмийг цуцалж,  
хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, 18.5, Засгийн газрын 2018 оны “Хорио цээр хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 266 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Баянгол, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Өлзийт, Гучин-Ус, Баян-Өндөр, Тарагт, Богд, Хайрхандулаан, Нарийнтээл сумдад хонины цэцэг өвчний тархалт тодорхой хэмжээнд буурч байгаа тул 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс өвчний голомттой нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт хонины цэцэг өвчний голомтын бүсийн хилийн заагийг 1 дүгээр, Гамшгаас хамгаалах тухай, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хязгаарлалтын дэглэмийн үед Иордан улсаас тусламжаар ирсэн урьдчилан сэргийлэх вакцин тарих хүн хүчийг томилон богино хугацаанд дархлаажуулан, вакцины дархлаа тогтох 14 хоногийн хугацаанд дээрх сумдад бог малын шилжилт хөдөлгөөн хийхгүй аймгийн Засаг даргын “Бог малын гоц халдварт цэцэг өвчинтэй тэмцэх тухай” 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын заалт бүрийг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Мал, амьтны гоц халдварт өвчний голомт бүхий бүс нутагт бог малыг тээвэрлэх, тууварлах шилжилт хөдөлгөөнийг хориглож, малаас гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдахгүй, хүн мал, амьтны бөөгнөрөл бий болгох арга хэмжээ зохион байгуулахгүй байх, гоц халдварт өвчний голомт бүхий сумдын мэргэжлийн анги, мэргэжлийн багийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Г.Чимэддагва), Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН


8224 11 0472

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн 113 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ОНОШЛОГДСОН ГОЦ ХАЛДВАРТ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ГОЛОМТЫН ЗУРАГЛАЛ**

2024.03.13



**ТАНИХ ТЭМДЭГ**

- Хязгаарлалтын дэглэмтэй
- Хориоцээрийн дэглэмтэй

Дэглэм	Сумын тоо	Голомтын тоо	Өрхийн тоо	Малын тоо
Хориоцээр	6	11	112	3739
Хязгаарлалт	5	10	132	3950
<b>НИЙТ ДҮН</b>	<b>11</b>	<b>21</b>	<b>244</b>	<b>7689</b>

0 10 20 30 40 Miles

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар  
сарын 20 -ны өдрийн 4134 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



**ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМИЙН ҮЕД  
АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Мэргэжлийн багийн ахлагч: Б.Алтанзул (Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга)

Гишүүд:

Ц. Төмөрбат (МЭТ, МЭҮН болон дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн, баталгаажуулалт, эмийн хяналтын асуудал хариуцсан хяналтын улсын байцаагч)

Б.Ариунцэцэг (Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)

Л.Оюунжаргал(Зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн)

А.Энхтүвшин (Өвчний мэдээ тайлан, цахим бүртгэл, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Т. Оюун-Эрдэнэ (Шимэгчтэх, халдваргүй өвчин, малын эм биобэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Х.Мөнхцэцэг (Лабораторийн эрхлэгч)

Э.Улам-Ундрах (Ариун цэвэр, магадлан шинжилгээний эмч)

Л.Баяр (Нян судлалын шинжээч эмч)

С.Саранцэцэг (Ийлдэс судлал, шимэгч судлалын шинжээч эмч)

Хонь, ямааны цэцэг өвчний голомт бүхий сумын Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч нар

-оОо-